

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хүүхэд хамгааллын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.15 дахь заалт:**

4.1.15. “хориотой агуулга” гэж Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.6-д заасныг;

**2/4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалт:**

4.1.16. “хүүхдэд хортой агуулга” гэж Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.7-д заасныг;

**3/25 дугаар зүйлийн 25.12 дахь хэсэг:**

25.12. Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана. Зөвлөл Ажлын албатай байна.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 6.32 дугаар зүйл нэмсүгэй:

“6.32 дугаар зүйл. Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих:

1. Хүүхдийн насаар баталгаажуулаагүй харилцаа холбооны сүлжээний дугаарыг хүүхдэд ашиглуулсан бол эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Хориотой болон хүүхдэд хортой агуулгыг нийгмийн сүлжээнд нийтэлсэн, түгээсэн, сурталчилсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Сургалтын үйл ажиллагаа, даалгавар, үнэлгээ, суралцагчтай холбоотой мэдээлэл солилцоход боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрснөөс бусад нийгмийн сүлжээний үйлчилгээг ашигласан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан технологи ашиглан хэрэглэгчийн насны бүлгийг баталгаажуулан бүртгэх, нийгмийн сүлжээний үйлчилгээнд 13 насанд хүрээгүй хүүхдэд бүртгэл үүсгэхгүй байх үүргээ биелүүлээгүй бол хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Хориотой болон хүүхдэд хортой агуулгыг устгах, технологийн арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нийгмийн сүлжээний үйлчилгээ үзүүлэгч хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн “6.31 дүгээр зүйл,” гэсний дараа “6.32 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг,” гэж, 6.26 дахь хэсгийн “6.28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг,” гэсний дараа “6.32 дугаар зүйлийн 4 дэх хэсэг,” гэж, 6.39 дэх хэсгийн “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “6.32 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, 6.50 дахь хэсгийн “6.30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “6.32 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2026 оны ... дугаар  
сарын ...ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН СҮЛЖЭЭНД ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ  
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дах хэсэг, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг 2027 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**2 дугаар зүйл.** Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсаас нийгмийн сүлжээний хэрэглэгч өөрийн насыг баталгаажуулах ажлыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хийнэ.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн сүлжээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**